

ОРОС БА ХЯТАД: ТЭНЦВЭРГҮЙ ТҮНШЛЭЛЭЭС СТРАТЕГИЙН СОРИЛТ РУУ

*Д.Баярхүү**

БНХАУ дэлхийн хэмжээний их гүрэн болж өсч өндийвөл олон улсын харилцааны бүхий л дүр зураг өөрчлөгдөнө. Хятадын өсөлт тэлэлт нь хөрш Азийн орнууд, АНУ-ын эрх ашгийг хөндөх нь мэдээж боловч Хятадтай 4000 гаруй км нийтлэг хил хязгаартай Орос орныг хамгийн ихээр түгшээж байгаа ажээ. Оросын өөрийнх нь судлаачдын үзэж байгаагаар, ийнхүү түгшихийн учир нь, Хятадын өсөлт Орос гүрний олон улсын байр суурь, нийгмийн дотоод төрх, хүн амын бүтэц, Еврази дахь байр суурьд нь шууд нөлөөлж буйд байгаа ажээ.¹

Үндэсний баялаг

БНХАУ өнөөдөр үндэсний эдийн засгийн хүчин чадлаараа ОХУ-аас хол даван гарч, Дэлхийн Банкны үзэж байгаагаар АНУ, Японы дараа гуравдугаар байр эзлэх болжээ. Гэтэл Орос нь арагшаа ухарч Тайваний дараа 17 дугаарт бичигджээ. Худалдан авах чадварын тэнцвэрээр (PPP: purchaisng power parity) хэмжвэл БНХАУ-ын ДНБ АНУ-ын ДНБ-ний 35 хувьд хүрчээ. 1990-ээд оны эхээр Хятадын ДНБ СССР-ийн түвшнээс доогуур байсан бол одоо 4 дахин давчихаад байна. Орос орон нэг хүнд ноогдох ДНБ-ээрээ Хятадаас 7 дахин илүү байсан цаг саяхан бол тун ойрын ирээдүйд энэ үзүүлэлтээрээ ард нь орох төлөвтэй. Энэчлэн Орос орон Хятадаас зүгээр нэг хоцроод зогсохгүй буурай орны хэмжээнд тулж очихтой тулгарч байна. Эрчим хүчний хангамж, экологи, санхүү-банкны систем, Азийн хямралын нөлөөлөл гэх зэрэг бэрхшээлүүд Хятадыг дайрч гарсан нь үнэн боловч Хятадын хувьд Оросын хөгжлийн түвшин бол нэгэнтээ үеэ өнгөрөөсөн түүх юм. Эдүгээ Хятадын хөгжлийн үйл явцыг гаднаас зогсоох буюу буцаах тийм хүч байхгүй болсон гэж дүгнэхэд дэгсдүүлэлт болохгүй.

Нийгмийн асуудлууд

Хятадын реформын дүнд дэлхийн хүн амын тавны нэгийг хувцаслаж, хооллож өлхөн дөнгөлөө. Цаашдаа Хятадын улсын үйлдвэрийн газруудыг шинэчлэх бодлогын хүрээнд хувьчлал явуулбал нийгмийн сүрхий сөрөг үр дагаварт хүргэнэ гэсэн болгоомжлол бий. Өнөөгийн байдлаар ажилгүйчүүдийн тоо 150 саяас давсан бөгөөд орон сууц, боловсрол, эрүүл мэндийн салбарт олон төрлийн бэрхшээлүүд хуримтлагдсан. Ийм нөхцөлд Хятадаас олон тооны хүн Орост цагаачлан

*Д.Баярхүү - профессор

гарч очих магадлалтай гэж оросууд өөрсдөө үзэж байна. Хятадаас 200-300 сая хүн цагаачлан гарлаа гэхэд тэдгээрийн 5 сая нь л ОХУ-д орж ирвэл Алс Дорнодын нийт хүн ам даруй 2 дахин өснө. Хятадын гэмт хэрэгтнүүд Орост нэвтрэн одоо ч хууль бус авирлан, зөвхөн Москвад 50000-100 000 Хятад хүн хууль бусаар оршин суудаг гэсэн тоо байх бөгөөд тэд хууль дүрмийг олонтаа зөрчдөг байна.

Соёл иргэншлийн хонзон

Коммунист суртал ёс төдий үлдэж, харин Хятадын өсөлтийг дагалдан их хятадын үндсэрхэг үзэл амилан дээд элит төдийгүй энгийн ард олны дунд газар авчээ. 1911 оны хувьсгалын үеэс хятадууд нэгдмэл үндэстэн гэдгээ ухамсарлах болж, үндэсний бахархал нь сэргэсэн. Хятадыг 150 жилийн турш дарангуйлж ирсэн барууныхан гэдэг дотор хятадууд Оросыг ч хамааруулж ойлгодог. Иймдээ ч жирийн хятадууд Орос гүрнийг өрнөдийн империалистуудтай адилтган үзэж, хилийн тухай тэгш бус гэрээ тулгасан, Манжуурыг колоничилсон, боксеруудын бослогыг дарсан, “социалист” гэгдэх лагерь дотроо “их ахын” байр сууринаас Хятадыг дарамталсан гэх зэргийн ялыг Орост тулгасаар иржээ. Амар мөрөн дэх Даманы арал орчмыг Хятадад эгүүлэн өгсөн Орос-Хятадын харилцааны түүх бичлэгт шинээр орж ирж буй энэ түүхт үзэгдлийг хятадууд үндэсний ялалт хэмээн олон үеэрээ шуугиулах бололтой.

1997 онд Хонконгийг Хятадад эргүүлэн нэгтгэсэн нь түүхэн утгаараа өрнөдийнхний давуу байдлын төгсгөл болсон хэмээн үздэг аж. 25 зууны түүхтэй өвөрмөц соёл иргэншилтэй үндэстэн болохынхоо хувьд Хятад нь дэлхийн хэрэг явдалд оролцож нөлөөлөх боломж Хятадын өмнө ийнхүү нээгдсэн бололтой.

Гадаад бодлого

БНХАУ-ын гадаад бодлогын зорилт нь хүч хуримтлуулахын тулд цаг хожих, эцсийн бүлэгт Хятадыг зөвхөн Азийн төдийгүй, дэлхийн хэмжээний нэгдүгээр зэрэглэлийн хүчирхэг гүрэн болгоход оршиж байна гэж Карнеги төвийн судлаачид дүгнэжээ. Энэ бодлогоо хэрэгжүүлэхийн тулд үзэл сурталжихаас зайлсхийх, бүх улс оронтой, юуны өмнө хөршүүдтэйгээ яриа хэлэлцээ явуулж, хамтран ажиллахад онцгой анхаарч байна. Орос, Япон, Энэтхэг, Индонези гэх мэт нөлөө бүхий улс оронтой Хятад нь хил залгаа, эсвэл ойр дөт оршдгоос гадна Азид нөлөө бүхий тоглогч болох АНУ-тай харьцах сорилтын үедээ байгаа. Хүч бололцоогоо үл тарамдах үүднээс ойр орчноо төвхнүүлэх, тухайлбал хөршүүдтэйгээ урт хугацааны сайн хөршийн харилцаа тогтоох нь гарцаагүй Хятадын хэрэгцээт шаардлага юм. Ойрын 10 жилд БНХАУ нь олон улсын тавцанд нэн болгоомжтой хянуур, бусадтай сөргөлдөхгүй

бодлого баримтлах бөгөөд аажимдаа Зүүн болон Төв Азид нэн идэвхитэй гадаад бодлого явуулах болно гэж Оросын судаачид дүгнэж байна.

Гадаад бодлогын стратегийн зорилтууд нь:²

- Хятадын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг дэлхийн хамтын нийгэмлэгээр болзол тавилгүй хүлээн зөвшөөрүүлэх (үүнд Тайвань, Түвд, Шинжаан нь Хятадын салшгүй хэсэг гэсэн статуст хамаарна)

- Өмнөд Хятадын тэнгис дэх БНХАУ-ын онцгой эрхийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх

- Зүүн Өмнөд Азид Филиппинээс Бирм хүртэл давамгайлах нөлөөлөл тогтоох

- АНУ, өрнөд болон Хятадын хооронд дэгдэх маргаанд байр сууриа хөршүүдээрээ дэмжүүлэх

- Монгол Улстай “онцгой харилцаатай” болохоо хүлээн зөвшөөрүүлэх

- Бусад улс орон Хятадын эсрэг эвсэл холбоонд нэгдэж орох нөхцөл үүсгэхгүй байх, цэргийн талаар Хятадтай сөргөлдүүлэхгүй байх

- Бусад улс орноос Хятадтай худалдаа-хөрөнгө оруулалтын талаар найрсаг бодлого явуулах нөхцлийг хангах

- Бусад улс орнуудаар бүс нутагт Хятадын тэргүүлэх үүргийг хүлээн зөвшөөрүүлэх (чухал шийдвэр гаргахаас өмнө Бээжинтэй албан бус хэлбэрээр ч болов заавал зөвлөлдөж байх)

- Бусад улс орон хятад цагаачдыг хүлээн авахад бэлэн байх нөхцлийг бүрдүүлэх

- Хилийн чанад дахь хуацяо нарын эрхийг Бээжингийн зүгээс хамгаалах эрхийг хүлээн зөвшөөрүүлэх

- Азид Хятад хэлээр ярих явдлыг хөхиүлэн дэмжих, хятадууд бөөнөөр амьдардаг газарт хоёр хэлээр ярьдаг болгох

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх явцдаа Хятад цэргийн хүч хэрэглэх нь эргэлзээтэй боловч өөрийн жин нөлөөгөөр бусдын хүсэл эрмэлзлэлийг дарамтлах мохоох чадавхитай. Эдийн засгийн хүч боломжоо гадаад бодлого, дипломатын гол хэрэглүүр болгон ашиглахын зэрэгцээгээр шаардлагатай гэж үзсэн тохиолдолд цэргийн хүч хэрэглэх магадлалтай.

Хятадын стратегийн байнгын сонирхлыг америкийн эрдэмтэн 3.Бжезинский дараахи байдлаар томъёолсон³ нь яг голоор нь хэлсэн бололтой.

1) Энх амгалан орших Зүүн өмнөд Ази
2) Эрэг орчмын бүс нутагт маргааныг хүч хэрэглэхгүй шийдэх
3) Хятадыг энх тайвнаар нэгтгэх
4) Солонгосын тогтвортой байдал
5) Хараат бус Төв Ази нь бие даан, эзэн мэдэх
6) Энэтхэг, Пакистаны хоорондын хүчний тэншвэр
7) Хүчирхэг эдийн засагтай ч, олон улсын хувьд хязгаарлагдмал байх ёстой Япон
8) Тогтвортой, гэхдээ хүчирхэг бус Орос

Өрнөдтэй харилцах талаар Хятад улс хоёрдмол бодлого явуулж, нэгэнт үүсэн бий болсон олон улсын харилцааны системийг хүлээн зөвшөөрдөггүй атлаа түүнийг шинэчлэх талаар санал хэлдэггүй. Олон туйлт ертөнц болон жанжлалыг үл зөвшөөрөх тухай ерөнхий үг хэлэх авч баруунаас өөртөө ашигтай бүхий л хөнгөлөлтийг шаарддаг.

АНУ-тай харилцах тухайд, Хятадын гадаад бодлогын тэргүүлэх гол чиглэл нь бөгөөд АНУ ч БНХАУ-тай олон улсын аюулгүй байдал, бүс нутгийн аюулгүй байдал, үй олноор хөнөөх зэвсгийн хяналт, байгаль орчны асуудал гэх зэргийн асуудлаар “стратегийн яриа хэлэлцээ” явуулах бодлого баримталж байна. Хоёр тал “Бүтээлч стратегийн түншлэл” тогтоох чиглэлээр ажиллахаа албан ёсны баримт бичигтээ тусгасан. Хятад-Америкийн харилцаа дэлхийн бодлогод нөлөөлөх утгаараа эдүгээ цагийн хамгийн чухал хоёр талын харилцаа юм. Үүнд хятадууд олзуурхах боловч хүч чадал мөхөс улмаас болгоомжтой хандаж байна. БНХАУ нь АНУ-тай харилцаагаа идэвхжүүлэхийг зорино, гэвч Зүүн Азид АНУ-ын нөлөөг хязгаарлах буюу багасгах бодлого баримтална. АНУ давамгайлж байсан ОХУ-АНУ-БНХАУ гэсэн гурвалжин нэгэнт задарч, түүний оронд сулавтар Японыг багтаасан Хятад-АНУ-Япон гэсэн шинэ гурвалжин үүсч байна. Хятадуудын хүсч байгаагаар, энэ гурвалжны АНУ, Хятад гэсэн хоёр орой нь тэнцүү байх учиртай гэнэ.⁴

Хятадын геополитик дэх гурван бүлэг гурван талт харилцаа ба түүний гол тоглогчид гэсэн шинэ ойлголт, нэр томъёо үүнтэй холбоотойгоор гарч иржээ.

1) Шилжилтийн үеийн стратегийн 5 гүрэн: Хятад, АНУ, Орос, Япон, Европ
2) Бүлэг 1 харилцаа: Хятад—АНУ—Орос
3) Бүлэг 2 харилцаа: Хятад—АНУ—Европ
4) Бүлэг 3 харилцаа: Хятад—АНУ—Япон ⁵

Ингэхэд Хятадын гадаад бодлогыг явуулдаг жинхэнэ субъект нь БНХАУ дангаараа байна уу, аль эсвэл БНХАУ-аас гадна Тайвань, Макао болон Зүүн өмнөд Азийн цагаач хятадуудыг багтаасан “Их Хятад” байна уу гэсэн асуудал үлэмж сонирхол татахуйц билээ.⁶ Нийтлэг соёл иргэншил, үндэс угсаа, хэл заншил бүхий хятад угсаатны хамтын нийгэмлэгээс уугуул нутаг болох эх газрын Хятад руу их хэмжээний хөрөнгө цутгаж ихэнх нь Тайваниас орж ирдэг. Эргэлдэж байгаа хөрөнгийн хэмжээ асар их юм. 50-60 сая орчим хятад цагаачид нийт 2.5 триллион долларын хөрөнгийн хөдөлгөөнийг хянаж байна. Дэлхийгээр тархсан цагаач хятадуудын оролцоо Хятадын өсөлтийг хангах томхон хөдөлгүүр, хөшүүрэг болж байна.

Ер нь түүхэн геополитикийн талаасаа Хятадын өсөлт дэвжилтийг 9 (7+2) үечлэлээр авч үзэж болохоор байна.

- 1) Манжийн Чин улсыг хүртэл Евразийн зах хүрээ- (Rimland)
- 2) Чин улсын үе-дэлхийд нээгдсэн, Еврази руу аажим тэлсэн
- 3) Дундад Иргэн Улс- ерөнхийдөө атлантист барууны
- 4) 1949-1960, Москвагийн эвслийн евразист БНХАУ
- 5) 1960-1970, геополитикийн бүрэн зожигрол
- 6) 1970-1990, прагматик-атлантист шинэчлэгдсэн Хятад
- 7) 1990-ээд оноос Орос-Хятадын XXI зууны түншлэл- Евразист⁷

- 8) Ирээдүйд “Берингийн хоолойгоос Тонкины булан хүртлэх шинэ эзэнт гүрэн” нь Оросын *Lenaland*-ыг бүхэлд нь эзлэнэ
- 9) 2020 он гэхэд Хятадын нөлөөний хүрээ тэлсээр “Их Хятадын” орон зай үүснэ (Монголыг оролцуулсан, хил дагуухи нийт 20 улс)⁸

Худалдаа

“Уралаас зүүн тийш” орших бүс нутагт ОХУ-ын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, эдийн засаг, соёлыг хөгжүүлэх, АПЭК мэт бүс нутгийн улс хоорондын аж ахуйн сүлжээнд нэгдэн орох явдал Оросын хувьд амин чухал эрх ашиг нь билээ. Энэ эрх ашгийг тууштай сахин хамгаалахад Оросын төв болон хязгаар нутгийн засаг захиргаа, эдийн засгийн салбарууд, бизнесуудын эрх ашиг зөрөлдөх явдал гол садаа юм. Үүнд хятадууд Оросын замбараагүй байдлыг мэдэхийн цаана мэдэх болсон бөгөөд үүнийг овжноор ашиглах болжээ. Орос орон Хятадад түүхий эдийн нөөц, зэвсэг нийлүүлэгчийн хувьд сонирхолтой байна. Оросын зэвсгийн экспортын 70-аад хувь нь Энэтхэг, Хятадад ногдог.

Цэрэг-техникийн хамтын ажиллагаанаас бусад эдийн засгийн харилцааны салбарт Орос нь Хятадын анхаарлыг төдийлөн татахгүй байна. 1950-иад онд СССР-ийн тусламжаар баригдсан үйлдвэр, аж ахуйн газруудыг Оросын тусламжтайгаар шинэчлэх сонирхолгүй. Харин цөмийн эрчим хүч, усан цахилгаан станц, сансрын аж үйлдвэр зэрэг салбарт Оросын тал өөрийн гэсэн байр суурь эзлэх боломжтой. Орос-Хятадын худалдааны эргэлт Хятад-Америкийн худалдааны эргэлтийн түвшнээс даруй 10 дахин бага байгаа.

Зэвсэглэл

БНХАУ жилд ДНБ-ний 2 хувь буюу 50-70 тэрбум долларыг цэргийн зорилгоор зарцуулж байгаа нь Оросынхоос хоёр дахин бага байна. Эргэн тойрны улс гүрнүүдийн зэвсгийн санд Хятадынхаас илүү орчин үеийн зэвсэг техник бий. Тиймээс ч Хятадад зэвсгийн модернизаци улайран хийж байна. Гэхдээ Хятад улс урт хугацаанд том дайн, цөмийн мөргөлдөөн гарахгүй гэж үздэг, албан ёсоор аль ч улс орныг өөрийн дайсан гэж үздэггүй, тиймдээ ч цөмийн зэвсэг түрүүлж хэрэглэхгүй байх үүрэг авсан цорын ганц гүрэн. Оросын цэргийн шинжээчид дээрхийг

эш үндэс болгон БНХАУ-ын цэрэг-улс төрийн эрмэлзлэл ойрын 10 жилд ОХУ-ын эсрэг чиглэхгүй гэсэн дүгнэлт хийжээ.

БНХАУ-ын цэргийн номлол, цэргийн төсөв зардал, цэргийн тоо, зэвсэглэл, анги нэгтгэлүүдийн байрлал, гадаадаас худалдан авч байгаа зэвсэг, технологитой холбогдсон бүх мэдээ сэлт хаагдмал хэвээр байна. Эдүгээ тэд ганцхан Тайванийн эсрэг хүч хэрэглэж болзошгүй, түүнчлэн хэрэгцээ гарвал Өмнөд Хятадын тэнгист хүч хэрэглэж болзошгүй. Энэ чиглэлээр цэргийн байгуулалтаа хөгжүүлж байна. Орос-Хятадын харилцаанд зэвсгийн худалдаанаас өөр чиглэлээр цэрэг-стратегийн асуудал чухал байр эзэлдэггүй.

Оросын тал түншлэлийн талаар ярьсаар байх авч Хятадыг найз нөхдийн тоондоо оруулдаггүй. Тухайлбал, Оросын Батлан хамгаалахын өмнөх сайд Сергей Родионов Хятадыг дайснуудынхаа тоонд оруулан нэрлэж байв. ТУХН, НАТО, Төв болон Зүүн Европын орнуудтай цэргийн салбарт хамтран ажиллах талаар Оросын цэргийн шинэчлэлийн баримт бичигт өргөн тусгасан байхад БНХАУ-ын талаар ганц ч үг дурдагдаагүй байна.

Хятадад олон цэнэгт хошуу бүхий цөмийн систем бүтээж байгаа ба 2010-2015 онд цөмийн цэнэгт хошуу 700-1000 нэгжид хүрч, БНХАУ-ОХУ-ын хооронд тэр үед л хүчний тэнцвэр үүсэх боломж нээгдэнэ. Цэрэг-стратегийн болзошгүй чиглэлийн хувьд, Хятадын ирээдүйн цэргийн хүч чадавхи АНУ-ын эсрэг биш, харин ч Оросын эсрэг ашиглагдана гэж Оросын цэргийн шинжээчид үзсээр байна. Харьцангуй чанар сайтай, үнэ хямд орос зэвсэг нь Хятадын зэвсэгт хүчнийг шинэчлэхэд мэдээж чухал боловч түүнээс илүүтэйгээр технологи худалдан авах, тэргүүний зэр зэвсгийн систем Оростой хамтран боловсруулахыг Хятад нь илүүтэй сонирхож байна.

Түншлэл

Оростой харилцах нь эцсийн бүлэгт эргэн тойрондоо таатай орчин бүрдүүлэх Хятадын бодлогын нэг хэсэг. Оросыг өөрийн эсрэг ирээдүйн аливаа эвсэл, холбоонд оруулахгүй байх нь чухал. 1991, 1994, 1996, 1997 онд БНХАУ, ОХУ болон Төв Азийн гурван орны хооронд хилийн асуудлаар явагдсан яриа хэлэлцээ, байгуулсан гэрээ хэлэлцээрүүд нь Орос-Хятадын харилцаа бүхэлдээ хэвийн болсны илрэл байв. Орост ноцтой үймээн самуун дэгдэх, дахин задрах аюул тулгарвал Хятадад шууд аюул болох юм. Тиймээс ч Орос орон хүчирхэг бус, харин тогтвортой хөгжихийг нь Хятад улс сонирхдог.

Зүүн хойд Азийн, Хятад-Америк-Японы гурвалсан харилцаанд, Солонгосын асуудлаар явагдаж байгаа 4 этгээдийн хэлэлцээнд ч ОХУ-ыг оролцуулахыг Хятадын тал яг мэрийж дэмжихгүй байгаа юм. Ирээдүйд бие даасан их гүрэн болж сэргэх эсэх нь тодорхойгүй байгаа Оросыг

алсаас ажиглан, болж өгвөл өөртөө татан дагуулахыг Хятад сонирхож байна. Оросын хувьд Хятадтай нягт харилцан, хамтран ажиллах нь урт удаан хугацааны зорилт, гарцаагүй шаардлага нь болж байна. Ойрын 15 жилд ОХУ нь БНХАУ-тай сөргөлдөх бүү хэл, харилцаагаа хурцатгах ч сонирхолгүй. АПЭК-т нэгдээд байгаа хэдий ч геополитикийн чиглэлээ алдсан Орос орон энэ бүс нутагт эдийн засаг-худалдааны орон зай байхгүйтэй адил болсон. Өсөн өндийж байгаа Хятад улстай улс төрийн салбарт давуу харилцаатай байх нь бүс нутгийн бусад улс оронтой харилцаагаа идэвхжүүлэхэд нь түлхэц болж өгнө. Тухайлбал, Орос-Хятадын харилцаа хөгжиж эхэлснээр Оростой харилцаагаа сайжруулах санаачилга гаргахад Японыг түлхэнэ гэж үзэж байна.

Оросын стратегийн хувилбар

БНХАУ-тай харьцуулан үзвэл, ОХУ өмнөд их хөрштэйгээ харилцаагаа хөгжүүлэх тодорхой стратегия яг таг боловсруулаагүй байгаа. Оросын зүгээс хувиа хичээсэн, өөр өөр үзэл бодолтой милитократ, партократ бүлэглэлүүд харилцаанд оролцож байдаг учраас стратегия маш зөв сонгон тогтоох ёстой. Чингэхгүй бол элдэв бэрхшээлд орно. Эрх ашгийн харилцан шүтэлцээн дээр тулгуурласан стратеги байх нь хамгийн бүтээлч гэж эрдэмтэд, шинжээчид үздэг байна. Энэ стратегийн зангилаа асуудлууд бол:

- Орос болон гадаадын (Өрнөд, Япон, Азийн) капиталаар, ТУХН, Хятад, Солонгосын ажлын хүчээр Алс Дорнод, Сибирийг эн тэргүүнд хөгжүүлэх

- БНХАУ-тай эдийн засаг, ШУТ-ийн харилцан шүтэлцээт систем бий болгох

- Япон, Солонгос болон АНУ-ыг оролцуулан бүс нутгийн орнуудтай тал бүрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх

- Оросын Алс Дорнод, Сибирийг хөгжүүлэх асуудлыг аль болох өргөн интернационалчлах нь энэ үйл явцыг хурдасгах боломж олгохын зэрэгцээгээр энэ газар нутгийг өрөөсгөлөөр хятадчлах явдлаас аврах юм.

БНХАУ-тай эдийн засгийн талаар харилцах ОХУ-ын үндсэн чиглэл нь нутгийнхаа зүүн хязгаарыг Оросын болон олон улсын бизнес эрхлэгчдэд тааламжтай болгох явдал юм. Үүнд асар их нөөц бүхий газрын тосны орд газруудыг эзэмших, тив алгассан хий дамжуулах хоолой тавих, тээврийн замуудыг нээх зэрэг том хэмжээний төслүүд багтаж байна.

ОХУ нь Япон, Солонгостой идэвхитэй харилцах хэмжээгээр БНХАУ-тай тогтвортой харилцах нөхцөл бүрдэх бөгөөд энэ хоёр оронтой давшингүй ажиллахгүйгээр “тэргүүний Азид” нэгдэн орж бас чадахгүй юм.

Нөгөө талаас Номхон далай дахь түнш АНУ-тай хэрхэн харилцахаа мөн харгалзах хэрэгтэй. Шинэ зуун Азийн эрин үе болно

гэж байгаа бөгөөд Европыг бодвол Орос, АНУ хоёр Азид хамтран хийх ажил ихтэй байх болно.

Төв Ази

Орос, Хятадын аль алин нь Төв Азид өөрийн гэсэн байр суурь, эрх ашигтай учир өөр өөрийн нөлөөг өргөжүүлэх сонирхолтой. Энэ бүс нутагт үндэстэн угсаатан, шашин шүтлэг, хил хязгаар, ус ашиглалт болон байгалийн нөөцийг хуваах гэх зэргийн асуудлаарх маргаан ойрын 10 жилд намжихгүй, харин ч гаднын оролцоотойгоор шийдвэрлэгдэж магад юм. Эрчим хүчний асар их нөөц бүхий Төв Ази маргааны талбар болж хувирав. Өмнөд Хятадын тэнгис, Тайвань, тэр бүү хэл Шинжааны дотоод зөрчилдөөн дотроо л үлдэж байвал Орост төдийлөн хүртээлтэй бус, иймд Хятадын ашиг сонирхол Төв Азид нэвчин орж ирэх нь Оросын амин чухал эрх ашгийг хөндөж, улмаар шахагдах тийшээ эргэж болзошгүй. Тэр үед АНУ гол тэнцвэржүүлэгчээр үлдэх биз ээ.

ШОС буюу “Шанхайн 5” хэмээх бүс нутгийн эвслийн тухайд, үйл ажиллагаа нь бүрэн төлөвшөөгүй байгаа тул үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй. Энэ эвсэл чухам хаана төвлөрөх, хэн нь хошуучлах, хэн нь дагалдах тухайд ч төсөөлөл байхгүй. Гэвч Хятад голлон тоглогч байх нь илүү магадлалтай. Эвслийн гишүүн 6 улс бүгдээрээ шилжилтийн үедээ байгаа тул төлөвшилт нь удаашрах болов уу. Нөгөө талаас 2001.09.11-ний үйл явдлын дараа ШОС-ийн зарим орны нутаг дэвсгэр, эргэн тойронд геополитикийн ба стратегийн гүн гүнзгий өөрчлөлт гарсан, одоо ч өөрчлөгдөж байна. Эдгээр өөрчлөлтүүд ШОС-ийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаагийн сацуу Иран, Пакистан, улмаар Энэтхэг улс энэ эвслийн гишүүн болох тухай яригдаж буй нь уг эвслийн үүрэг зорилго, чиглэлийг бүр ч бүрхэг болгож байна.

Стратегийн шинэ гурвалжин дөрвөлжингийн харьцаа

2004 сүүл рүү олон улсын харилцаа төсөөлснөөс өөр эргэх магадлалтай болж байна. Энэ нь Орос-Хятадын харилцаанд шууд хамааралтай гэхээсээ АНУ-ын геополитикийг очиж түнших хэмжээнд илэрч байна.

1) Хятадын асар их тэлэлтийг тогтоон барих, тэнцвэржүүлэх чиглэлээр Энэтхэг-Япон-Тайванийн “Триалоги”⁹ (Гурвалсан харилцаа буюу “Гурвалжин”) үүсгэх асуудал судлаачдын 2 дахь сувгаар яригдаж эхлэв. Ардчилал, хүний эрх, эрх чөлөөгөөр нийтлэг энэ гурав Азийн томхон 5 эдийн засгийн гурав нь болохын хувьд технологи, эдийн засаг, соёлын салбарт хорших санаачилга Энэтхэгээс үүдсэн бололтой. Энэ санааг анхлан БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ж.Фернандес гаргаж, сайдаасаа огцорсны дараа Тайваньд очиж “Триалоги”-ийн

асуудлаархи семинарт оролцож мөн санаагаа нотолжээ. Тайванийн Ерөнхий сайд Ю Сикунь мөн үзлийг дэмжиж мэдэгдэл хийжээ.

2) АНУ-д Ж.Буш Ерөнхийлөгчөөр улиран сонгогдсоны дараа мексик гаралтай Альберто Гонсалес гэгчийг Ерөнхий прокуророороо томилж, энэ нь Бразилд БНХАУ-ын Дарга Ху Зиньтао айлчилсантай давхцан нэгэн “Дөрвөл”-ийн асуудал босч ирэв.¹⁰ Олон улсын харилцааны үндсэн 5 туйл (АНУ, Европын Холбоо, Орос, Энэтхэг, Хятад) дээр Бразил нэмэгдэж олон улсын харилцааны шинэ бүтэц үүсэх тухайд яригдаж буй бололтой. Орос-Энэтхэг-Хятад-Бразилийн стратегийн альянс нь англосаксыг сөрөх шинэ хувилбар байж болох юм. АНУ-Латин Америкийн харилцаа хэврэгшсээр, Иракийн дайнаас үүдэн АНУ-ын байр суурь суларч буй нөхцөлд исламын ертөнц рүү энэ дөрвөл нөлөөлөх нэвчих шинэ оролдлогууд гарч эхлэв. Кашмирын асуудал дээр Энэтхэг буулт хиймээр болж, АНУ-ын эвслийн хүрээнд бус Оросын цэргийнхэн Ирак руу очихоо зарласан зэргээс нотолгоо хийж болно. Энэ хувилбар хэрэгжсэн нөхцөлд АНУ нь Иран, Хойд Солонгосыг хэт чангалахаа азнаж, Хятадыг тойруулсан стратегийн шинэ бүслүүр үүсгэх магадлалтай юм.

Орос-Хятад ба Монгол

Дээр бичсэн санаа дүгнэлтүүдээс ургуулан энд хөндөх онцгой сэдэв бол Монгол Улс яах вэ, хэрхэн тусгах вэ гэдэг асуудал юм. Урт удаан хугацааны турш Монгол нь эхлээд Японы эсрэг, дараа нь БНХАУ-ын эсрэг Москвагийн үнэнч холбоотон байсан түүх бол хоёр талын найрамдлын эгэл түүх биш юм. Монголын нутаг дэвсгэрт Зөвлөлтийн 100 мянган цэргийн хүчтэй бүлэглэл байрлаж байсан нь дайн болох тохиолдолд Хятадын нийслэл рүү хүчтэй давшилт зохион байгуулах таатай боломжийг Москвад олгож байсныг эдүгээ нуугаад яахав.

Өнөөгийн Монгол Улс түүхэндээ анх удаа улс төрийн бодит тусгаар тогтнолоо эдэлж байна. Тэрээр түүхэн хоёр жанжлагчийнхаа ивээлээс салахын тулд гурав дахь (АНУ, Япон) орнуудтай харилцаа тогтоохыг хичээж байна. Гэхдээ л жирийн хятадууд Монголыг өөрийн түүхэн хамжлага, Хятадын түүхэн эзэнт гүрний хэсэг гэж үзэж сурчихсан, энэ нь төрийн бодлогод очиж нөлөөлөх эсэх нь ирээдүй цагийн асуудал юм. Бүс нутагт БНХАУ-ын байр суурь хүчтэй болсон нөхцөлд Монголд Хятадын сюзеренитетыг ямар нэг хэлбэрээр сэргээн тогтоох боломж бүрдэж болох талтай. Үүнийг үгүйсгэхгүй. Монгол Улс хэтдээ Хятадын геополитикийн тойрогт орж ирэх нь Орост шууд аюул болох нь юу бол, Алс Дорнод, Сибириэр тэртэй тэргүй нөлөөллөө алдаж буй. Харин Орос-Хятадын харилцаа огцом муудаад 1970-1980-аад оны байдал тэр хэвээрээ давтагдвал хаа хаанаа байдал аюултай болж

мэдэх юм. Оросын эрх ашгийн үүднээс аваад үзвэл Монголыг ор тас үгүйсгэх буюу дорд үзэх нь харалган хэрэг. Хуучин хамжлагынхаа нутаг дэвсгэрт Хятад улс хүч нөлөөгөө тэлж байгаа энэ нөхцөлд Монголын улс төрийн тусгаар тогтнолыг бэхжүүлэх асуудал Орос улсаас АНУ болон Японтой хүч хавсрахыг шаардаж мэдэшгүй юм. Энд би Карнегийн төвийн судлаачдын зарим дүгнэлтийг эш таталгүй толилуулж байна.

Оросын судлаачдын дээрхи дүгнэлтүүдээс үзэхэд, Орос-Хятадын харилцаанд Монголын хүчин зүйл цаашид ч оршиж, энэ харилцааны хөгжил нь Монгол Улсын стратегийн хувилбарын сонголтыг залуурдсаар байх болно гэж дүгнэхээр байна. Орос орон эрх ашиг нь хөндөгдвөл Монголыг золиослож ч болзошгүй, бүр үндэсний эрх ашгаа урагшлуулах үүднээс Монгол Улсын эрх ашиг, улс төрийн тусгаар тогтнолд ч харш тохиролцоонд хүрэхгүй гэхийн баталгаа үгүй байна.

Орос орны дотоод байдал тогтворгүй, эв нэгдэлгүй, улс төрийн олон хүчний эрх ашиг харшилдан сөргөлдсөн, ард түмэн нь ядуурлын доод түвшинд нэлээд хугацаагаар үргэлжлэн зовбол, ийм байдал нь Хятадад ямагт олз болж, Хятадын Орос дахь тэлэлт урагшлах болов уу. Шинжаанаас эхэлж тэсрэн яваандаа газар авах салан тусгаарлах оролдлого Хятадад үүсэхийг бас үгүйсгэж болохгүй. Хөрш хоёр орны байдал ийнхүү тогтворгүй болж ирвэл Монголын аюулгүй байдалд сүрхий заналхийлэл учрах нь гарцаагүй. ХХI зууны дэлхийн хөгжлийн төв Зүүн Ази ба Номхон далайн бүс нутаг руу шилжиж байгаа, мөн түүнчлэн БНХАУ хөгжлийн түвшин хурдаар ОХУ-аас хол давж, дэлхийн хэмжээний 2 дахь их гүрэн болох хандлагатай байгаа нь Монголын хувьд стратегийн цоо шинэ орчин юм. Энэ орчинд бид Хятад, Оросын гадаад бодлогын чиглэл, хандлагуудыг гойд мэдрэн анхаарч, хоёр хөршийн стратегийн ашиг сонирхлын мөргөлдөөн Монголд тусахаас сэрэмжлэх бодлого явуулах учиртай болов уу.

ИШЛЭЛ ЗҮҮЛТ

1. 1997 оноос Москва дахь Карнеги төвөөс Орос-Хятадын харилцааны талаар цуврал семинар зохион байгуулсан. Эдгээр семинарын үеэр яригдсан дүгнэлтүүд болон судлаачдын хийж буй дүгнэлтүүдийг энд тоймлон танилцуулав.
2. Хятадын гадаад бодлогын стратегийн зорилтуудыг Карнеги төвийн дэд захирал Д.В.Тренин ийнхүү тодорхойлжээ
3. Збигнев Бжезинский. Великая шахматная доска, М., 1998
4. Shen Qiang. Viewing the Adjustments and Changes of Relationship among Great Powers through Three Groups of Trilateral Relations, *Peace and Developmet*, Beijing, 4/2002
5. Мөн тэнд
6. “Их Хятад” гэдэг ойлголт бол бие биенээ тэтгэсэн эдийн засгийн бүтцийн тухай асуудал юм.
7. А.Дугин. Основы геополитики, М., 1997
8. Zbigniew Brzezinski. A Geostrategy for Eurasia, *Foreign Affairs*, 1997, September/ October,
9. Radio Taiwan International, News, 2004/11/12-13/
10. Teocracia Bushiana: Entre Gaffney y Kissinger, *La Jornada*, 16.11.2004